



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын ерөнхий дүгнэлт: Усны тухай хуулийн зарим заалт хэрэгжихгүй байна.

Аудитын нэр: Усны тухай хуулийн хэрэгжилт



**Зуунмод хот
2017 он**

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	
Төв аймаг дахь Төрийн аудитын газар	Товчилсон үгсийн тайлбар 3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4 Асуудал 1 Зарим сумд усны сан бүхий газарт энгийн хамгаалалтын бүс тогтоон улмаар ИТХ-ын шийдвэрээр орон нутгийн тусгай хамгаалалтад авчээ..... 6 Асуудал 2 Хүн амын ундны болон ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг бүрэн ногдуулж бодитой төлөвлөөгүй байна..... 13 Асуудал 3 Усны мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлж, мэдээлж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллаагүй байна..... 21
Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал	
Аудитын менежер О.Амаржаргал	
Аудитор Ц.Базарсад Ц.Саранчимэг	
2017 оны 07 дугаар сарын 18-ны өдөр	Дүгнэлт 26 Зөвлөмж 27 Холбогдох байгууллагын санал:
Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал 28
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар 70272582, 70272463 дугаарын утас, 70273204 дугаарын факсаар харилцана уу	
ХАЯГ: Төв аймгийн Төрийн байгууллагын 2-р ордон	

Товчилсон үгийн тайлбар

МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭАХН	Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
БОНХЯ	Байгаль орчин ногоон хөгжлийн яам
БОНХАЖЯ	Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
БОХ	Байгаль орчны хяналт
ХХТХГ	Хан Хэнтийн тусгай хамгаалалтын газар
БОХУБ	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
БОАЖГ	Баягалт орчин аялал жуулчлалын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
МУИХ	Монгол улсын их хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ААН	Аж ахуйн нэгж
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ДЭХГ	Дулааны эрчим хүчний газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТТХТ	Татвар төлөгчтэй харилцах тасаг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**Аудит хийсэн үндэслэл**

Аудитыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын захиалга, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Холбогдох хууль тогтоомж, ус хөтөлбөр болон нөхөн сэргээх бодлогын хэрэгжилт, эдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулахаар аймгийн хэмжээнд гарсан шийдвэрийн биелэлтийг хангуулах үйл ажиллагаа нь Усны тухай хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд нийцлийн аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ.Үүнд:

- Усны нөөц, хамгаалалт, ашиглалт зохистой эсэх
- Усны төлбөрийг бүрэн төвлөрүүлж чадаж байгаа эсэх
- Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тооцож байгаа эсэх

Аудитад аймгийн БОАЖГазар, аймаг, сумын ИТХ, бүх шатны Засаг даргын Тамгын газар, Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлогын хэлтэс, ХХААГазар, МХГазрын холбогдох ажилтнууд, Татварын хэлтэс, сумдын татвар, БОХ-ын байцаагчид, холбогдох аж ахуйн нэгжүүдийг хамруулан тэдгээрийн ажлын тайлан, статистик мэдээ, судалгааны материалууд аймгийн ИТХ-аас баталсан төлөвлөгөө, аймгийн Засаг даргатай хийсэн гэрээний хэрэгжилтийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, АДБОУС 4100, нийцлийн, гүйцэтгэлийн, санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Усны тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
- Ус үндэсний хөтөлбөр МУИХ-ын 2010 оны 24 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоол

- Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”
- Засгийн газрын 2006 оны 137 дугаар тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журам”
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол бусад холбогдох шийдвэр
- Холбогдох бусад хууль, тогтоомж, эрхийн акт, стандартууд

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын менежер О.Амаржаргал удирдан, аудитор Ц.Базарсад, Ц.Саранчимэг нар 2016 оны 05-р сарын 10-наас 07-р сарын 18-ныг дуусталх хугацаанд хийж гүйцэтгэв.

Асуудал 1

Зарим сумд усны сан бүхий газарт энгийн хамгаалалтын бүс тогтоон улмаар ИТХ-ын шийдвэрээр орон нутгийн тусгай хамгаалалтад авчээ.

1.1 Усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын бүс тогтоосон уу?

Аймгийн БОАЖГазраас ирүүлсэн судалгаагаар нийт 915 усны эх үүсвэр, усан сан бүхий газар байгаагаас 11 сумын 420 усан сан бүхий газар буюу 45.9 хувьд нь энгийн хамгаалалтын бүс тогтоож орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан байна.

Төв аймаг усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авч сууршлын бүс үүсгэхгүй байх бодлого баримтлан ажилласан байна.

Аймгийн БОАЖГазрын усны тооллогын судалгаагаар 915 усны эх үүсвэр, усан сан бүхий 11 сумын 420 усан сан бүхий газар буюу 45.9 хувьд нь энгийн хамгаалалтын бүс тогтоосон байна. Бүс тогтоосон байдлыг сумаар жагсаавал

№	Сумын нэр	аймаг сумын ИТХТ-ийн тогтоол, шийдвэрийн огноо дугаар		Усан сан бүхий газрын тоо
1	Баянцагаан	2012.05.16	19	108
2	Алтанбулаг	2012.05.20	28	3
3	Баян-Өнжүүл	2012.05.08	18	18
4	Баянхангай	2012.05.10	18	4
5	Баянцогт	2012.05.03	28	7
6	Зуунмод	2013.03.27	44	2
7	Бүрэн	2013.12.27	73	13
8	Дэлгэрхаан	2014.06.05	31	11
9	Жаргалант	2014.03.31	1	21
10	Аргалант	2014.11.13	75	4
11	Эрдэнэ	2017.01.30	4	229
	Нийт дүн			420

Мөн түүнчлэн усны энгийн хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авсан байна. Аймгийн ИТХ-ын 2015 оны аравдугаар хуралдааны 8 тоот тогтоолоор Алтанбулаг, Баян, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Баянцогт, Борнуур, Бүрэн, Дэлгэрхаан, Заамар, Жаргалант, Сэргэлэн, Эрдэнэсант, Зуунмод зэрэг сумдын усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох, тэмдэгжүүлэхэд нэг суманд 2.0 сая төгрөг буюу нийт 26.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Дээрх төлөвлөгөөний дагуу зарцуулах 26.0 сая төгрөгийг тэмдэгний зардал 19.4 сая төгрөг, тэмдэг суулгах зардал 2.2 сая төгрөг, тэмдэг татах шатахуун 2.2

сая төгрөг, тээврийн хөлс 2.2 сая төгрөг буюу нэг суманд 0.9-1.1 сая төгрөгийг зарцуулж 27 суманд энгийн хамгаалалтын бүс тэмдэгжүүлэх ажлыг хийсэн байна.

Хамгаалалтын бүс тогтоож тэмдэгжүүлэхээр ИТХурлын тогтоолын хавсралтаар 13 сум нэр зааж орсон боловч гүйцэтгэхдээ 27 сумыг хамруулан гүйцэтгэсэн бөгөөд бусад 14 суманд энгийн хамгаалалтын бүс тогтоосон эсэх нь нотлогдохгүй байна.

1.2 Гол, мөрөн, нуур, усны эх үүсвэр болон газрын доорх цэнгэг усны орд газрыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авсан уу ?

16 сумын 262485.6 га талбай бүхий гол, мөрөн, нуур, усны эх үүсвэр болон газрын доорх цэнгэг усны орд газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 10 дугаар сарын 27-ны хурлаар Ус үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг авч хэлэлцээд усны сан бүхий газарт онцгой, энгийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоож, орон нутгийн тусгай хамгаалалтанд авч холбогдох газруудын мэдээллийн санд оруулах ажлууд хангалттай хэрэгжиж чадаагүй байна гэж дүгнэн 48 дугаар тогтоол гаргасан байна.

Энэхүү тогтоолын 2.2.1-д гол мөрний урсац бүрдэх эхийн зааг, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн муж, хамгаалалт, хязгаарлалт, эрүүл ахуйн бүсийг стандарт шаардлагад нийцүүлэн тогтоох ажлыг үргэлжүүлж, тогтоогдсон бүс бүхий газрыг орон нутгийн тусгай хамгаалалт, хэрэгцээнд авах гэсэн заалтаар тодорхой үүрэг өгөгдсөн. Үүний дагуу аймгийн ИТХурлын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 5-р хуралдаанаар Төв аймгийн орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг 901484.4 га-гаар шинэчлэн тогтоосон байна.

Үүнээс гол, мөрөн, нуур, усны эх үүсвэр болон газрын доорх цэнгэг усны орд газрыг 16 сумын нутаг дэвсгэрийг хамруулын 262485.6 га-р тогтоож орон нутгийн тусгай хамгаалалтад авсан байна.

Сумын нэр	Тусгай хамгаалалтад авах зорилго	Газрын нэр байршил	га-гаар
Баяндэлгэр	Голын сав газрыг хамгаалах	Галуутын гол орчмын газар	7932
Баян-Өнжүүл	Бөөр нуруу үе мөч арьс өнгөний өвчинд хэрэглэдэг рашааны нөөц багасч байгаа	Хундаганы рашаан	84
Баян-Өнжүүл	Хужир шүү ховордож буй тул хамгаалах	Харийн нуур	864
Баян-Өнжүүл	Ходоод элэг цөсний эмчилгээнд ашигладаг	Оорцгийн рашаан	1
Баянцагаан	Эмчилгээний зориулалттай шавартай	Бумбагар, Тэрвий, Өлзийт нуур	11858.8
Баянцагаан	Рашаан усны эхийг хамгаалах	Элгэн булаг	86.2
Баянцогт	Эмчилгээний зориулалтаар ашигладаг тул хамгаалах	Бөгтөр нарсны рашаан	1.5
Баянцогт	Эмчилгээний зориулалтаар ашигладаг тул хамгаалах	Бага төхөм рашаан	1.5
Борнуур	Усны эх үүсвэрийг хамгаалах	Шивэртийн гол, Хөндлөн булаг	1360
Баянчандмань	Рашаан усыг эмчилгээ сувилгааны журмаар ашиглаж байгаа	Далны рашаан	1.5
Борнуур	Элэг цөсний эмчилгээнд ашиглах	Саарал морьтын тойром	100
Дэлгэрхаан	Байгалийн унаган төрхийг хамгаалах	Сумын төвийн дээд нуур	152
Жаргалант	Төвийн усны эх болон ундрагыг хамгаалах	Баянхошуу	1148
Цээл Угтаал	Хүн малын ундны эх үүсвэр	Номтын булаг	1
Зуунмод	Хүн малын ундны эх үүсвэр	Зуунмодны гол	122
Мөнгөнморьт	Байгалийн унаган төрхийг хадгалах, ховордсон ан амьтан хамгаалах	Байдлагийн хөх нуур	87.3
Мөнгөнморьт	Ой, усны ай сав газрыг хамгаалах	Сумын зарим газар нутгийг	218051
Сэргэлэн	Зуунмод сумын ундны усны эх булаг хагалбар газар	Хөшгийн хөндий	5014

Сэргэлэн	Байгалийн баялагийн зүй зохистой ашиглах	Уртын гол	3474
Сүмбэр	Хүн малын ундны эх үүсвэр учир хамгаалах	Загдлын гол	3152
Эрдэнэ	Рашаан усны эх байгалийн унаган төрхийг хамгаалаах	Өвөржанчивлан	2909
Эрдэнэ	Рашаан усны эх байгалийн унаган төрхийг хамгаалаах	Аржанчивлан	491
Эрдэнэ	Ойт хээрийн өмнөд хэсгийн ойн төгөл усны эх булаг	Баян даваа, тамган өндөр	5592.8
Эрдэнэсант	Усны эх үүсвэр рашаан усыг хамгаалах	Хойд бөөр булаг	1
	Нийт дүн		262485.6

1.3 Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг улс, орон нутгийн төсөв, байгаль хамгаалах сан, аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлсэн үү?

2014-2016 онуудад аймгийн төсвөөс усны нөөцийг зүй зохистой, ашиглах хамгаалахад 813.3 сая төгрөг, бусад эх үүсвэрээс нийт 151 булаг шанд, гол горхи, хөв цөөрөм, рашаан усны эхийг хамгаалахад 221.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулинд ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын 35 хувийг усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хашиж хамгаалах, судалгаа шинжилгээ хийх ажилд зарцуулах заалтыг үндэслэн Байгаль орчны хамгаалах чиглэлээр 2014-2016 онд аймгийн төсвөөс 37 арга хэмжээнд 2022.4 сая төгрөгийг зарцуулахаар батлагдаж, үүнээс усны нөөцийг хамгаалах арга хэмжээнд 9 ажилд 1197.2 сая батлагдаж, гүйцэтгэлээр 813.3 сая төгрөг зарцуулагдсан байна

Хамрагдах хугацаа	Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлэх		үүнээс усны нөөцийг зүй зохистой, ашиглах хамгаалах арга хэмжээ		
	арга хэмжээний тоо	батлагдсан зардал мян.төг	арга хэмжээний тоо	батлагдсан зардал мян.төг	Гүйцэтгэл мян.төг
2014	26	932200.0	2	227900.0	220604.7
2015	9	593400.0	5	472500.0	283100.0
2016	2	496800.0	2	496800.0	309600.0
дүн	37	2022400.0	9	1197200.0	813304.7

Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014-2016 онд нийт 9 арга хэмжээнд 813.3 сая төгрөг зарцуулсан зардлын гүйцэтгэлийг арга хэмжээ тус бүрээр харууллаа.


№	Төсөл арга хэмжээний, нэр байршил	Хамрах хүрээ	Батлагдсан төсөвт өртөг /мян.төг/	Гүйцэтгэл
Усны нөөцийг зүй зохистой, ашиглах хамгаалах арга хэмжээ				
1	Зуунмод сумын хэмжээнд орон сууц бүхий айл өрхүүдийн хэрэглээний цэвэр усыг тооллууржуулахад шаардагдах усны тоолуур, холбох хэрэгслийг нийлүүлэх.	Зуунмод	177,900.0	172,679.0
2	Сумдад булаг, шандын эхийг хамгаалах ажил	20 сум	50,000.0	47,925.7
2014 он дүн			227,900.0	220,604.7
3	Хөрсний бохирдлыг бууруулах хүрээнд гэр хороололыг цэвэр бохир усны байгууламжтай болгох	Зуунмод	200,000.0	10,600.0
4	Баянцогт сумын үерийн хамгаалалтын даланг засаж тохижуулах төсөл хэрэгжүүлэх	Баянцогт	161,500.0	161,500.0
5	Усны тооллого явуулах, ард иргэд, ААНБ-ийн оролцоог нэмэгдүүлэн	сумдад		

	сургалт суртчилгаа явуулах		5,000.0	5,000.0
6	Хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд цэвэрлэх байгууламж барих	Сүмбэр	80,000.0	80,000.0
7	Сумдын усны сав бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох	сумдад	26,000.0	26,000.0
2015 он дүн			472,500.0	283,100.0
8	Зуунмод сумын 11 худгийн усыг автоматжуулж, тоолууржуулах,	Зуунмод	300,000.0	287,300.0
9	Зуунмод, Аргалант суманд хөв цөөрөмд байгуулах	2 сум	196,800.0	22300.0
2016 он дүн			496,800.0	309,600.0
Сүүлийн 3-н жилийн дүн			1,197,200.0	813,304.7

Аймгийн ИТХурлын 2015 оны арван нэгдүгээр хуралдааны 12 сарын 04-ний өдрийн 09 дугаар тогтоолын 4-р хавсралтаар 2016 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд Зуунмод сумын усан санг автоматжуулж, тоолууржуулах төслийг санхүүжүүлэхэд 300.0 сая төгрөг, Аргалант, Зуунмод голын эхэнд хөв цөөрөм байгуулахад 186.3 сая төгрөг нийт 486.3 сая төгрөг төлөвлөсөн байна. Зуунмод, Аргалант суманд хөв цөөрөм байгуулах ажил нь зураг төсөв хийгдээгүйгээс нэр, зориулалт өөрчлөгдөн 22.3 сая төгрөгийг зураг төсвийн ажилд санхүүжүүлсэн, Зуунмод сумын усан санг автоматжуулж, тоолууржуулах ажилд 300.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр батлагдаж Зуунмод суманд 10 усан сангийн барилга, тоног төхөөрөмж суурилуулах, усны нөөцийн сав нийлүүлэхэд 287.5 сая төгрөгийн ажил хийгдсэн байна.



Булаг шанд, гол горхи, хөв цөөрөм, рашаан усныг эхийг хамгаалсан байдлыг 2010-2016 онуудын судалгаагаар нийт давхардсан тоогоор 97 суманд 151 булаг шанд, гол горхи, хөв цөөрөм, рашаан усны эхийг хамгаалахад 221.5 сая төгрөгийн эх үүсвэрийг Байгаль хамгаалах сан, тогтвортой амьжиргаа-2 төсөл, ААН, малчны бүлэгүүдээс санхүүжсэн байна.




1.4 Усны барилга байгууламжийн тооллого зохих журмын дагуу хийгдсэн үү?

Нийт худгийн тоо сумдаас ирсэн судалгаагаар 2730, БОАЖГазрын судалгаагаар 2380, ХХААГазрын судалгаагаар 2108 худагтай гэж гарч байгаа бөгөөд усны тоо бүртгэлийг нэгтгэн зангидаж бодлого тодорхойлж буй байгууллага байхгүй байна.

Усны тухай хуулийн 7.3-д “Усны тоо бүртгэлийг аймаг, нийслэл, сум дүүргийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга жил бүр зохион байгуулж улсын мэдээллийн санд оруулна” гэж заасан. Энэ заалт аймгийн хэмжээнд бүрэн хэрэгжихгүй байна.


Хуулийн дагуу жил бүр тооллого хийгддэггүйгээс сумдаас ирүүлсэн судалгаа, аймгийн БОАЖГазар, ХХААГазраас ирүүлсэн судалгаа нь хоорондоо ихээхэн зөрүүтэй байна. Үүнд: өрөмдмөл худгийн тоо сумд 1611, БОАЖГазар 1364, ХХААГазар 871, Богино яндант худгийн тоо сумд болон БОАЖГ 493, БОАЖГ 407, Энгийн уурхайн гар худаг сумд 626, БОАЖГ 609, ХХААГ 744 худагтай гэсэн зөрүүтэй судалгаа ирүүлсэн байна.



Байгаль орчны сайдын 2006 оны 269 дүгээр тушаалаар батлагдсан “Усны тоо бүртгэл явуулах журам”-ын 1.3-д “Усны тоо бүртгэлийг аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, Усны хэрэг эрхлэх газар тогтоосон журмын дагуу зохион байгуулж, тайлан мэдээг нэгтгэн гаргана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллахгүй байна.

Сумдын судалгаагаар гарсан нийт 2730 худгаас 639 худаг буюу 23.4 хувийг данс бүртгэлд тусгасан гэсэн мэдээ гарч байна.

Мөн түүнчлэн худгийн ашиглалтын байдал, хугацаа, эзэмшигч, төрөл, зориулалт, лабораторийн шинжилгээг албан ёсоор хийлгэсэн эсэх, худгийн барилга байгууламжийг паспортжуулсан талаар нэгдсэн судалгаагүй байна. БОАЖГазар нь 2380 худгийн судалгааг ирүүлснээс 513 худагийн техникийн паспортын баталгаажуулалт хийж, 2012-2017 онд мэдээллийн санд бүртгэсэн нь нийт худгийн 21.5 хувийг эзэлж байна.



“Төв Чандмань-ДЭХГ” ОНӨҮГ нь Зуунмод хотын хэмжээнд дулаан хангамж, усан хангамж, ариутгах татуурга, орон сууцны мэргэжлийн үйлчилгээг хариуцан ажиллаж байна. Зуунмод сумын нийт ус хэрэглэгчдийг он тус бүрээр харуулбал

№	Хэрэглэгчийн тоо	2014 он	2015 он	2016 он
1	ААНБ-ын хэрэглэгч			
	тоолууртай	100	100	175
	тоолуургүй	15	15	2
2	Айл өрхийн хэрэглэгч			
	тоолууртай	325	470	757
	тоолуургүй	1232	1087	1137
3	Нийт			
	зөөврийн	3068	3068	3751
	Нийт хэрэглэгч	4740	4740	5822

2016 оны байдлаар Зуунмод сумын нийт төвлөрсөн системээр ус хэрэглэгчдээс 175 аж ахуйн нэгж байгууллага буюу 98.8 хувь нь, 757 айл өрх буюу 39.9 хувь нь тус тус тоолуураар ус хэрэглэж байна.

Аймгийн хэмжээний ус хэрэглэгч, ашиглагчдын усны хэрэглээг тоолууржуулах ажил дорвитой хийгдээгүй, ус ашиглагч, ус хэрэглэгч, аж ахуйн нэгж байгууллага, иргэний нэгдсэн судалгаа байхгүйгээс тоолууртай хэрэглэгчийн тоог гаргах боломжгүй байна.

Зуунмод сумын цэвэр ус, ариутгах татуургын асуудлыг Ус суваг, орон сууц, дулаан хангамжийн “Төв Чандмань-Дулааны эрчим хүчний газар” ОНӨҮГ хариуцан ажиллаж, аймгийн төвийн орон сууцны 1894 хэрэглэгч, гэр хороололд зөөврийн ус түгээх байрнаас 3255 хэрэглэгч буюу нийт 16 мянга гаруй хүн амыг усаар хангаж байна. Ус хангамжийн эх үүсвэрийн 5 гүний худаг (1-р багт 2 гүний худаг, Хөшгийн хөндийд 3 гүний худагтай), ус нөөцлөх 250 м3 багтаамжтай 1, 1000 м3 багтаамжтай 2 усан сан, 20.5 км цэвэр ус түгээх шугамтай. Олборлон түгээж буй усны хэмжээ хоногт 1100-1300 м3 байдаг байна. Гэр хороололд зөөврөөр 15 ус түгээх байр, 4 гүний худаг, ус зөөврийн 2 машин ажиллаж байна.

Асуудал 2

Хүн амын ундны болон ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг бүрэн ногдуулж бодитой төлөвлөөгүй байна.

2.1. Ус ашиглуулах дүгнэлтийг хуулийн дагуу бүрэн гаргуулж, усны мэдээллийн санд бүртгүүлсэн үү?

Ус ашиглуулах дүгнэлт гаргуулаагүй, ус ашиглах зөвшөөрөл аваагүй иргэн, аж ахуйн нэгж байгууллага 316 буюу 74.4 хувийг эзлэж байна.

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-т “хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв цөөрөм байгуулах, суваг шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана” гэж заасан. Аймгийн хэмжээнд 2014-2016 онд 109 иргэн, аж ахуйн нэгж ус ашиглуулах дүгнэлт гаргуулсан байна.Үүнд:

1. “хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргана” гэсний дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй уул уурхайн 15 аж ахуйн нэгжид Монгол ус ТӨҮГазар дүгнэлт гаргасан байна.
2. “хоногт 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа дүгнэлт гаргана” гэсний дагуу үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа 5 аж ахуйн нэгжид, Туул голын сав газар, Умард говийн сав газрууд дүгнэлт гаргасан байна.
3. “хоногт 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв цөөрөм байгуулах, суваг шуудуу татах дүгнэлтийг аймгийн байгаль орчны алба дүгнэлт гаргана” гэсний дагуу ус ашиглагч 89 аж ахуйн нэгж, байгууллагад аймгийн БОАЖГазар дүгнэлт гаргасан байна.

Мөн хуулийн 28.6-д “28.4-д заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг “хоногт 100 шоометрээс их ус ашиглах тохиолдолд сав газрын захиргаа, хоногт 50-100 шоометр ус ашиглахад аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хоногт 50 шоометрээс бага ус ашиглахад сум дүүргийн Засаг дарга зөвшөөрлийг олгож мэдээллийн санд бүртгэнэ” гэж заасан нь мөн хэрэгжихгүй байна. Сумдын хувьд ус хэрэглэгч, ашиглагчийн судалгаа огт байхгүй байна.

Усны тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар эрх бүхий байгууллага дүгнэлт гаргаж зөвшөөрөл олгосны үндсэн дээр ус ашиглах гэрээ байгуулснаар усны төлбөр төлөх хэмжээг тогтоож байна.

Мөн хуулийн 28.7-д “хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ус хангагч байгууллага нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дүгнэлт гаргуулж, сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авна” гэсэн заалт хэрэгжихгүй байна. Төв Чандмань ДЭХГазар ОНӨҮГазар нь

БОАЖЯамнаас ус ашиглуулах дүгнэлт гаргуулаагүй, ус ашиглах зөвшөөрлийг Туул голын сав газраас аваагүй, ус ашиглах гэрээ байгуулаагүй ажиллаж байна.

Аймгийн 14 суманд төвлөрсөн халаалтын системийн үйл ажиллагаа явуулж байгаа Ану-Сервис ХХК, Өнөрмандал ББН, Тэлмэн тэнүүн ХХК, Эл Си Би ХХК-ууд ус ашиглах зөвшөөрөл аваагүй, дүгнэлт гаргуулаагүй, гэрээ хийгээгүй ажиллаж байна.

№	Нэгдсэн халаалтаар хангагч байгууллага	Сумын тоо	Сумын нэр
1	Ану сервис ХХК	8	Заамар, Угтаалцайдам, Дэлгэрхаан, Жаргалант, Цээл, Лүн, Борнуур, Сүмбэр
2	Эл Си Би ХХК	3	Баянхангай, Баян-Өнжүүл, Өндөрширээт
3	Өнөрмандал ББН	1	Батсүмбэр
4	Тэлмэн тэнүүн ХХК	1	Баянчандмань
5	Төв Чандмань ДЭХГ ОНӨҮГ	1	Бүрэн
	нийт дүн	14	


БОАЖГазрын ирүүлсэн судалгаагаар аймгийн хэмжээнд нийт ус хэрэглэгч, ашиглагч 425 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас 109 аж ахуйн нэгж буюу 25.6 хувь нь ус ашиглах дүгнэлт гаргуулсан байна. 316 ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус ашиглуулах дүгнэлт гаргуулаагүй, ус ашиглах зөвшөөрөл аваагүй байгаагаас үзэхэд усны төлбөрийн төлөвлөлтийг бодитой хийж чадахгүй байна.

2.2. Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг ногдуулж, бүрэн төлөвлөсөн үү?

2016 онд аймгийн хэмжээний дүгнэлт гаргуулсан 30 аж ахуйн нэгжүүдээс 10 аж ахуйн нэгжид буюу 33.3%-д нь ус ашигласны төлбөр ногдуулсан байна.

Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.11, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтуудын дагуу ус ашиглуулах дүгнэлт гаргуулан, зөвшөөрөл авч гэрээ байгуулснаар ус ашиглах эрх үүсч байна. Уг дүгнэлтэнд Байгаль орчны Сайдын 1995 оны 153 дугаар тушаалаар батлагдсан “нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах ус хэрэглээний түр норм”-ыг үндэслэн тухайн байгууллагын хоногийн усны хэрэглээг тооцож, Засгийн газрын 2011 оны “усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” 302 дугаар, 2013 оны “усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай” 326 дугаар, “ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүрийг өөрчлөн батлах тухай” 327 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн усны нөөц ашигласны төлбөрийг ногдуулж байна.

БОАЖГазрын усны мэргэжилтний ирүүлсэн судалгаагаар аймгийн хэмжээнд усны мэдээллийн санд бүртгэлтэй 425 ус ашиглагч ААН, байгууллагуудаас 2014-2017 онуудад 37.6 хувь буюу 109 байгууллага ус ашиглах дүгнэлт гаргуулсан байна.



2016 онд аймгийн хэмжээний дүгнэлт гаргуулсан 30 аж ахуйн нэгжүүдээс 10 аж ахуйн нэгжид буюу 33.3%-д нь ус ашигласны төлбөр ногдуулсан байна.

УСНЫ НОГДУУЛАЛТ, ТӨЛӨВЛӨЛТИЙГ ЗЭРЭГЦҮҮЛЖ ҮЗҮҮЛБЭЛ

д/д	сумын нэр	2016 оны төлөвлөгөө			2016 оны гүйцэтгэл		
		Татварын хэлтэс	СТСХэлтэс	зөрүү	Татварын хэлтэс	СТСХэлтэс	зөрүү
1	Алтанбулаг	9.6	3.4	6.2	4.0	4.2	0.2
2	Аргалант	1.8	0.5	1.3	1.8	1.8	-
3	Архуст	0.6	0.2	0.4	0.9	0.9	-
4	Батсүмбэр	2.8	2.1	0.7	1.7	1.7	-
5	Баян	16.9	52.8	(35.9)	81.5	81.5	-
6	Баяндэлгэр	0.9	0.9	-	0.9	0.9	-
7	Баянжаргалан			-			-
8	Баян-өнжүүл	1.7		1.7	2.6	2.6	-
9	Баянхангай			-			-
10	Баянцагаан	1.2	1.2	-	0.5	0.5	-
11	Баянцогт	1.5	1.7	(0.2)	1.7	1.7	-
12	Баянчандмань	27.4	78.5	(51.1)	19.8	77.7	57.9
13	Борнуур	6.3	5.5	0.8	4.8	4.8	-
14	Бүрэн			-			-
15	Дэлгэрхаан	3.3	3.0	0.3	3.3	3.0	(0.3)
16	Жаргалант	91.9	62.5	29.4	62.0	62.0	-
17	Заамар	888.9	1,291.4	(402.5)	1,270.1	1,212.2	(57.9)
18	Лүн	0.8	1.0	(0.2)	1.0	1.0	-
19	Мөнгөнморьт	0.9	0.9	-	0.9	0.9	-
20	Өндөрширээт			-			-
21	Сэргэлэн	296.2	312.1	(15.9)	320.4	319.4	(1.0)
22	Сүмбэр	0.3	0.3	-	0.4	0.4	-
23	Угтаал			-		-	-
24	Цээл			-		0.3	0.3
25	Эрдэнэ	56.7	53.3	3.4	52.2	52.2	-
26	Эрдэнэсант		0.01	(0.01)	0.01	0.01	-
27	Зуунмод	5.0	7.2	(2.2)	8.0	8.0	-
	нийт дүн	1,414.7	1,878.5	(463.8)	1,838.5	1,837.7	(0.8)

Дээрх хүснэгтээс үзэхэд:

- Татварын хэлтсийн ирүүлсэн ногдуулалт, Санхүү төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн ногдуулалт 463.8 сая төгрөгөөр, гүйцэтгэл 0.7 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан.
- 6 суманд ус ашигласны төлбөр огт ногдуулаагүй байна.

УСНЫ ТӨЛБӨРИЙН НОГДУУЛАЛТЫГ СУМДААР ҮЗҮҮЛБЭЛ

д/д	сумд	ус ашиглагчдын тоо	сая:төг					
			үүнээс:					
			Татвар ногдуулсан			Татвар ногдуулаагүй		
			тоо	аймагт үйлдвэр үйлчилгээний зориулалтаар	суманд унд ахуй, рашаан ашигласны төлбөр	тоо	аймагт үйлдвэр үйлчилгээний зориулалтаар	суманд унд ахуй, рашаан ашигласны төлбөр
1	Алтанбулаг	29	8	9.1	0.6	21		
2	Аргалант	9	6	1.8		3		
3	Архуст	10	2	0.4	0.2	8		
4	Батсүмбэр	33	8	2.8		25		
5	Баян	14	1	16.9		13		
6	Баяндэлгэр	6	2	0.7	0.2	4		
7	Баянжаргалан	2				2		
8	Баян-өнжүүл	10	4	1.7		6		
9	Баянхангай					0		
10	Баянцагаан	4	1	0.9	0.3	3		
11	Баянцогт	22	2	1.2	0.3	20		
12	Баянчандмань	44	19	27.2		25		
13	Борнуур	41	7	6.3		34		
14	Бүрэн					0		
15	Дэлгэрхаан	1	1	3.0	0.3	0		
16	Жаргалант	53	9	91.8		44		
17	Заамар	25	15	889.0		10	459.9	
18	Лүн	6			0.3	6		
19	Мөнгөнморьт	9	3	0.9		6		
20	Өндөрширээт					0		
21	Сэргэлэн	43	15	296.2		28	15.9	
22	Сүмбэр	7	2	0.3		5		
23	Угтаал	2				2		
24	Цээл	3				3		
25	Эрдэнэ	40	25	34.2	15.5	15	9.2	1.1
26	Эрдэнэсант					0		
27	Зуунмод	10	2	5.0		8		
	Нийт дүн	425	132	1389.3	17.9	293	0	0

Судалгаагаар мэдэгдэж байгаа нийт ус ашиглагч, хэрэглэгч 425 иргэн, аж ахуйн нэгжээс чөлөөлөгдсөн 17 аж ахуйн нэгж, үйл ажиллагаа явуулаагүй 12 аж ахуй нэгж, иргэн, 132 аж ахуйн нэгж буюу 38.0 %-д ногдуулалтыг хийж, 293 аж ахуйн нэгж буюу 68.9 %-д ногдуулалт хийгээгүй байна.

Аудитын явцад усны төлбөрийн ногдуулалт, төлөвлөлттэй холбоотой зарим зөрчлүүд гарч байна.

- Эрдэнэ сумын татварын байцаагч 2016 онд ус ашиглагчидад хийсэн ногдуулалтыг төсвийн төсөлд тусгахдаа үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглах усны төлбөрийг 17 аж ахуйн нэгжид 43.4 сая төгрөгөөр ногдуулалт хийгдсэн байхад төсвийн төсөлд 14 аж ахуйн нэгжид 34.2 сая төгрөг буюу 9.2 сая төгрөгөөр, рашааны төлбөрийг 5 аж ахуйн нэгжид 23.7 сая төгрөг ногдуулсаныг 4 аж ахуйн нэгжид 22.5 сая төгрөг буюу 1.1 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн байна.
- Заамар сумын татварын байцаагч усны төлбөрийн ногдуулалтыг төсвийн төсөлд тусгахдаа алт олборлогч 22 аж ахуйн нэгжид 1349.3 сая төгрөгийн усны төлбөрийн ногдуулалт хийснийг 15 аж ахуйн нэгжээр 889.0 сая төгрөг буюу 459.9 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн.
- Борнуур суманд усны төлбөр төлөх 41 аж ахуйн нэгж байхад 7 аж ахуйн нэгжид ногдуулалт хийсэн

- Батсүмбэр суманд 33 аж ахуйн нэгж байхад 8 аж ахуйн нэгжид ногдуулалт хийсэн,
- ДЭХГазар нь жил бүр Усны тухай хуулийн 28, 29-р зүйлд заасан ус ашиглах дүгнэлт, зөвшөөрөл гаргуулж, гэрээ байгуулан ажиллахгүй байгаа талаар өмнөх бүлэгт дурьдсан. 2015 онд нэг удаа Зуунмод сумын хүн, амын болон үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар 427940 м3 ус ашиглах зөвшөөрлийг Туул голын сав газраас олгосон байна. Гэтэл 2016 онд ДЭХГазрын ашиглах усны хэмжээг 33300 м3-р тооцсон буюу 3.3 сая төгрөгийн ногдуулалт хийжээ. Тус байгууллагын гаргаж ирүүлсэн тайлангаар 2016 онд гүйцэтгэлээр 532100 м3 ус олборлосон гэж тайлагнажээ. Үүнээс үзэхэд усны төлбөрт 52.7 сая төлөх, ус ашиглах зөвшөөрлөөс 104160 м3 ус илүү олборлосон байна.
- Их хэмжээний ус ашиглаж байгаа услалтын системтэй газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, иргэн, нэгдсэн халаалтаар хангаж байгаа аж ахуйн нэгжүүдэд ус ашигласны төлбөрийн ногдуулалтыг огт хийдэггүй байна.

Орон нутгийн төсөвт унд ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг 4 сумын 15 байгууллагад 1.5 сая төгрөг, рашаан ашигласны төлбөрийг 4 сумын 8 аж ахуйн нэгжид 16.2 сая төгрөг нийт 17.7 сая төгрөгийн ногдуулалтыг 8 сум буюу 3.3 хувьд хийсэн нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 10.1.2-т “хүн амын ундны болон ахуйн зориулалтаар ашигласан усыг шоо метрээр тооцож төлбөр ногдуулна” гэсэнтэй нийцэхгүй байна.

Хүн амын унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны төлбөрийн орлогыг бүх суманд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тус бүрээр ногдуулалтыг хийж орлогыг бодитой бүрэн төлөвлөхгүй байна.

ХХААГазраас ирүүлсэн судалгаагаар аймгийн хэмжээнд 10 суманд 48 услалтын системээр 3353.8 га-г усалгаажуулах хүчин чадалтайгаас 2016 онд 1793.7 га-г ашиглах төлөвлөгөөтэй байсныг бүрэн ашиглаж үр тариа 73.0 га, төмс 598.6 га, хүнсний ногоо 342.9 га, малын тэжээл 572.0 га, жимс жимсгэнэ 206.8 га, бусад ургамал 0.4 га-д тус тус тариалсан ч усны төлбөр ногдуулаагүй байна.



2.3. Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлсэн үү?

2016 оны усны төлбөрийн орлогыг 384.6 сая төгрөг буюу 27.7 хувиар давж биелүүлсэн ч 556.1 сая төгрөгийн дутуу төлөлттэй байна.

Усны тухай хуулийн дагуу усны хэрэглээг зориулалтаар нь дараах байдлаар ангилна.Үүнд:

- ✚ “ус ашиглагч” гэж ашиг олох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээндээ ус, усан орчин, рашааныг ашигладаг, иргэн аж ахуйн нэгж байгууллагыг,
- ✚ “ус хэрэглэгч” гэж ашиг олох зорилгогүйгээр унд, ахуйн болон гэр бүл, өрхийн хэрэгцээний мал аж ахуй, газар тариаланд ус, усан орчинг ашигладаг хэрэглэгчийг тус тус хэлнэ.

Ус хэрэглэгчид нь усны үйлчилгээний төлбөрийг орон нутагт, ус ашиглагчид нь усны нөөц ашигласны төлбөрийг аймгийн төсөвт тус тус төвлөрүүлдэг байна.

Төсвийн тухайн хуулийн 23.6.5-д заасны дагуу үйлдвэрийн зориулалтаар ашигласан усны нөөцийн төлбөрийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн төлбөрийн орлогын 35 хувийг “Байгаль нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасны дагуу ус рашааны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх талаар тусгагдсан зорилт, арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулан аймгийн төсвөөс нэгдсэн журмаар зарцуулдаг байна.

Ус ашигласны төлбөрийн орлого төвлөрүүлсэн байдлыг он тус бүрээр харуулав.

/сая төгрөгөөр/

№	Ус ашигласны төлбөр	2014 он				2015 он				2016 он			
		ТӨ	ГҮЙ	зөрүү	хувь	ТӨ	ГҮЙ	зөрүү	хувь	ТӨ	ГҮЙ	зөрүү	хувь
	Нийт орлого	1413.4	2036.0	622.6	144.0	1634.8	1721.2	86.4	105.2	1414.7	1838.5	423.8	229.9
1	Орон нутагт	61.3	57.3	-4.0	93.5	77.7	58.8	-18.9	75.6	25.4	64.6	39.2	254.3
2	Аймагт	1352.1	1978.7	626.7	146.3	1557.1	1662.4	105.3	106.7	1389.3	1773.9	384.6	127.7

Хүснэгтээс үзэхэд:

2014 онд

- ❖ Унд ахуйн зориулалтаар ус ашигласны орлого 4.0 сая төгрөг буюу 6.5 хувиар тасарсан.
- ❖ Үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашигласны орлого 626.7 сая төгрөг буюу 46.3 хувиар давж биелэсэн.

2015 онд

- ❖ Унд ахуйн зориулалтаар ус ашигласны төлбөрийн орлого 18.9 сая төгрөг буюу 24.4 хувиар тус тус тасарсан байна.
- ❖ Үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашигласны орлого 105.3 сая төгрөг буюу 6.7 хувиар давж биелэсэн.

2016 онд


- ❖ Унд ахуйн зориулалтаар ус ашигласны орлого 39.2 сая төгрөг буюу 154.3 хувиар давж биелэсэн.
- ❖ Үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашигласны орлого 384.6 сая төгрөг буюу 27.7 хувиар давж биелэсэн.

Ус ашигласаны төлбөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийг харуулав.


/ сая. төгрөг/

№	Сумдын нэрс	2014 он				2015 он				2016 он			
		Ахуйн ус		Үйлдвэрлэлийн ус		Ахуйн ус		Үйлдвэрлэлийн ус		Ахуйн ус		Үйлдвэрлэлийн ус	
		төл	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төл	гүйц	төлөв	гүйц
1	Алтанбулаг	1.9	0.9	3.4	1.7	1.6	1.6	15.0	25.0	0.6	0.6	9.0	3.3
2	Аргалант			2.5	0.7				1.5			1.8	1.8
3	Архуст	0.2	0.2		0.2	0.2	0.2	0.10	0.6	0.2	0.2	0.4	0.7
4	Батсүмбэр		0.09	2.0	2.6			2.5	1.4		1.5	2.8	0.2
5	Баян		1.1	31.3	31.0	1.0	0.4	31.0	125.7			16.9	81.5
6	Баяндэлгэр	0.2	0.3	0.2	6.9	0.2	0.2	0.7	0.6	0.2	0.2	0.7	0.8
7	Баянжаргалан			11.9	5.9	0.5	0.5	12.0					
8	Баян-өнжүүл			0.5	0.1			0.5	1.0			1.7	2.6
9	Баянцагаан	1.2	0.1			0.8	0.8		1.0	0.3	0.5	0.9	0.06
10	Баянцогт	0.3	0.3	1.9	1.9	0.3	0.3	1.8	1.0	0.3	0.4	1.2	1.2
11	Баянчандмань			17.6	23.8			21.5	24.7	0.2	0.2	27.2	19.6
12	Борнуур		0.1	9.3	6.9	0.1	3.7	2.2	4.8		0.7	6.3	4.1
13	Бүрэн			1.2			0.4	2.5	2.2				
14	Дэлгэрхаан				4.4	17.8			5.9	0.3	0.3	3.0	3.0
15	Жаргалант	8.6	1.9	80.4	87.4		0.4	85.0	93.4			91.8	62.0
16	Заамар	9.7	2.1	861.0	1392.5	3.5		1021.9	1010.5		14.8	888.9	1255.2
17	Зуунмод	0.4	4.6	24.5	5.5	0.7	3.3				2.4	5.0	5.6
18	Лүн		0.4	1.0			0.8	0.8		0.7	0.9		
19	Мөнгөнморьт	0.4			1.4	0.5			0.9		0.01	0.8	0.9
20	Өндөрширээт												
20	Сүмбэр	0.2	0.7			0.7	2.4					0.3	0.3
21	Сэргэлэн		2.9	262.1	354.0		0.7	290.2	289.5			296.1	320.4
22	Цээл			9.8				8.3					
23	Угтаал-Цайдам			3.8				50.0	1.1				
24	Эрдэнэ	36.2	41.5	27.8	57.7	49.7	42.8	11.0		22.4	41.6	34.2	10.6
25	Эрдэнэсант					0.1	0.1		3.0		0.1		
	Нийт	61.3	57.3	1352.1	1978.7	77.7	58.8	1557.1	1662.4	25.4	64.6	1389.3	1773.9

Ахуйн зориулалтаар:



Үйлдвэрлэлийн зориулалтаар:



2016 онд ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлого 39.2 сая төгрөгөөр, үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлого 384.6 сая төгрөгөөр тус тус давж биелэсэн боловч 0.84-29.8 сая төгрөгөөр 7 сум үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны төлбөрийг тасалдуулсан, 7 сум үйлдвэрлэлийн зориулалтаар ус огт ашигладаггүй байна.

Хэдийгээр төлөвлөгөө жил бүр давж биелэж байгаа боловч ус ашиглагч, хэрэглэгчдийн судалгаанд үндэслэн усны дүгнэлтийг гаргуулж ногдуулалтыг бүрэн гүйцэд хийдэггүйгээс 8 суманд 0.3-366.3 сая төгрөгөөр давж биелэсэн байна.

- Татварын судалгаагаар оны эхэнд усны төлбөр 42.3 сая төгрөгийн дутуу төлөлттэй, 16.8 сая төгрөгийн илүү төлөлттэй гарсаныг тайлант онд суутган тооцдоггүй орсон төлбөрийн хэмжээгээр гүйцэтгэлийг тооцож зөрүүтэй тайлагнаж байна.
- 2016 оны эцэст усны төлбөр 556.1 сая төгрөгийн дутуу, 59.5 сая төгрөгийн илүү төлөлттэй гарсан байна.
- 2016 оны усны төлбөрийг 384.6 сая төгрөг буюу 27.7 хувиар давж биелэсэн хэдий ч 556.1 сая төгрөгийн дутуу төлөлттэй байна.

Төсвийн орлого нэмэгдүүлэхээр 2017 оны төсвийн төсөлд ус ашигласны төлбөрийг орон нутгийн орлогод 69.7 сая төгрөг, аймгийн төсвийн орлогод 595.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж нийт ус ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг 1934.9 сая төгрөг болгохоор санал оруулсаны дагуу Аймгийн ИТХ-ын 2017 оны 5 дугаар сарын 30-ны 02 тоот тогтоолоор ус ашигласны төлбөрийн орлогыг 450.2 сая төгрөгөөр нэмж тодотгон батласан.

2.4 Ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус бохирдуулсны нөхөн төлбөрийг бүрэн төлсөн үү

МХГазраас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар Усны тухай хуулийн 25 зүйлд заасны дагуу ус бохирдуулсны болон хомсдуулсны төлбөр, нөхөн төлбөр тогтоогдоогүй байна.

Усны тухай хуулийн 25.1-д Ус бохирдуулагч нь хаягдал усныхаа тоо хэмжээ, найрлагад хяналт тавих, хаягдал усны стандартын шаардлагад нийцүүлэн бохир усыг цэвэрлэж зайлуулах, ус бохирдуулсны төлбөр төлөх үүрэг хүлээнэ гэсний дагуу “Төв Чандмань ДЭХГ” ОНӨҮГ нь бохир усыг татан зайлуулах цэвэрлэх байгууламжийг 2011 онд ашиглалтанд оруулснаар ариутгах татуургын 35.2 км урт шугам сүлжээ, 400 гаруй бохир усны хяналтын худгаар дамжуулан хоногт 1200-1600 м3 бохир усыг 96% хүртэл цэвэршүүлэн зайлуулж байна.

Цэвэр болон бохир усны мэдээ					
№	Үзүүлэлт	хэмжих нэгж	2014	2015	2016
1	Олборлосон ус	Мян.м3	514.8	440.5	532.1
2	Усны шугамын алдагдал	Мян.м3	242.7	0.05	0.04
3	Нэмэлт усны зарцуулалт	Мян.м3	48.9	63.4	63.4
4	Гал унтраахад хэрэглэсэн ус	Мян.м3	0	0.11	0.13
5	Борлуулсан ус	Мян.м3	223.2	298.1	286.6
6	Зайлуулсан бохир ус	Мян.м3	173.2	352.4	399.0

2016 он, 2017 оны эхний хагас жилд аймгийн МХГазраас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар Усны тухай хуулийн 25 зүйлд заасны дагуу ус бохирдуулсны болон хомсдуулсны төлбөр, нөхөн төлбөр тогтоогдоогүй байна.

Асуудал 3 Усны мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлж, мэдээлж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллаагүй байна.**3.1 Усны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн хяналт шалгалт үр дүнтэй байна уу**

Усны тухай хуулийн 19 дүгээр зүйлд заагдсан бүрэн эрхийн дагуу хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Усны тухай хуулийн 19 дүгээр зүйл Сум, дүүргийн байгаль хамгаалагчийн бүрэн эрхийн 19.1.1-д “хариуцсан нутаг дэвсгэртээ усны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгах арга хэмжээ авах”, 19.1.2-д “ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг хууль тогтоомжийн дагуу ногдуулж, төлөлтөд хяналт тавих”, 19.1.4-д “энэ хуулийн 28.6-д заасан зөвшөөрлийг үндэслэн ус ашиглагчтай гэрээ байгуулан эрхийн бичиг олгож бүртгэх, мэдээллийг сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлэх” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж хяналт, шалгалтыг хийсэн тайлан мэдээ гаргаагүй байна.

Аймгийн МХГазраас 2016 онд Усны тухай хуулийн дагуу ус ашиглагчид олгох зөвшөөрлийг ашиглах усны эх үүсвэр, эсхүл рашааны эх булаг, түүний байршлыг харуулсан зураг, ус рашааны нөөц, чанар, найрлагыг тогтоосон хайгуул, судалгааны тайлан, ашиглах боломжит нөөцийн талаарх дүгнэлт, хоногт ашиглах усны хэмжээ, зориулалт, барилга байгууламжийн зураг төсөл, үйлдвэрлэлийн хүчин чадал, техник, эдийн засгийн үзүүлэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан, дүгнэлт зэрэг баримт бичиг зохих журмын дагуу бүрдүүлэн ус ашиглах зөвшөөрөлтэй эсэхэд давхардсан тоогоор ус ашиглагч 58 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна.

МХГазраас уул уурхайн чиглэлээр үйлдвэрлэл явуулж буй аж ахуйн нэгжид хийсэн шалгалтаар Усны тухай хуулийн 28.4-д “Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана” гэсэн заалтыг зөрчиж ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, гэрээ байгуулаагүй Монголросцветмет ХХК-д 3.84 сая төгрөг, Мондулаан трейд ХХК-д 7.68 сая төгрөгийн төлбөрийн акт ногдуулсан байна.

Мөн зөрчил гаргасан Тод ундрага ХХК, Эс Би Эф ХХК, Алтандорнод Монгол ХХК-д албан шаардлага өгч, Итгэл түшиг ХХК, Монполимет ХХК, Жотойн бажууна ХХК, Илтгоулд ХХК-д зөвлөмж өгч хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

Баянцогт сумын “Хайртхаан” амралтын газарт Аймгийн МХГазраас хийгдсэн зөвлөн туслах үйлчилгээний дүнг үндэслэн ус ашиглах дүгнэлт гаргуулах “Усны тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалт, ус ашиглах эрхийн бичиг авах 28.6 дах заалт, 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтын дагуу “ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах” гэсэн заалтын дагуу

компаний эзэмшилд байгаа худагт тоолуур тавьж баталгаажуулах зөвлөмжийг 2016 оны 07-р сард өгсөн байна. Гэтэл жилийн дараа буюу 2017 оны 6-р сард тус сумын ус ашиглагч нарын судалгааг гаргуулан усны дүгнэлт гэрээг шалгахад МХГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож ажиллаагүй орхигдуулсан байна.

Аймгийн МХГазраас 2017 оны эхэнд “Төв Чандмань ДЭХГ” ОНӨҮГ-т байгаль орчны чиглэлээр төлөвлөгөөт шалгалтыг хийсэн байна. Шалгалтанд Зуунмод суманд ажиллаж буй халаалтын 9 хэсэг, төв цэвэрлэх байгууламж, Одонт хөтөл дэх цэвэр усны нөөцийн сан, цэвэр усны гүний 5 худаг, зөөврийн 7 усан сан, СӨХ-ны үйл ажиллагаа хамрагдсан байна. Энэхүү шалгалтаар ус ашиглах дүгнэлт 2015 оноос хойш хийгдээгүй, ус ашиглах эрхийн бичиггүй, ус ашиглах гэрээгүй, ус ашигласны төлбөр төлсөн нь гэрээ байгуулаагүй тул төлбөр төлсөн үндэслэл, хэмжээ нь зөв эсэх нь тодорхойгүй байсан зэрэг зөрчил илэрсэн байна. Мөн усан хангамжийн эх үүсвэрт хяналт шалгалтыг явуулахад төвлөрсөн ба төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэр, ус түгээх цэгийн эрүүл ахуйн бүсийн хамгаалалтын байдлыг үнэлэхэд зарим эх үүсвэрийн онцгой хамгаалалтын бүсийг хашаажуулаагүй, бохирдол үүсэхээс хамгаалаагүй, ус хангамжийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас газрын аюулгүй байдлыг хамгаалалтанд аваагүйгээс бусдын эзэмшил, ашиглалтад олгогдох, шугам сүлжээ гэмтэх, эвдрэх улмаар иргэдийн эрүүл аюулгүй орчинд байнгын үйлчилгээг тасралтгүй авах эрх зөрчигдэх нөхцөл бий болсон гэж МХГазраас дүгнэсэн байна. Шалгалтаар дээрх нөхцөл байдал болон илэрсэн зөрчлийг арилгах талаар 5 зөвлөмж санал хүргүүлж ажилласан байна.

Төв аймгийн Угтаалцайдам суманд байрлах Ану сервис ХХК-ны халаалтын зуухны үйл ажиллагаанд хяналт шалгалт 2017.05.19-нд хийгдсэн байна. Шалгалтаар ус ашиглах дүгнэлт, гэрээ, эрхийн бичиггүй нь “Усны тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх заалт, 28.11 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтыг зөрчснийг илрүүлэн зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага өгөгдсөн байна.

3.2 Ус ашиглалтын болон усны бүртгэлийг хугацаанд нь үнэн зөв гаргаж хүргүүлсэн үү

Усны харилцааны талаарх нэгдмэл удирдлагаар ханган, цэвэр усны нөөц, хомсдол, ашиглалт, бохир ус цэвэрлэх байгууламж, усны чанарын төлөв байдал, гадаргын усны чанарын мэдээллийг жил бүрийн дүнгээр үнэн зөв мэдээлж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Үндэсний статистикийн хорооны даргын зөвшөөрснөөр Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны 11-р сарын 08-ны өдрийн А/361-р тоот тушаалаар “Цэвэр усны нөөц, хомсдлын 20...оны жилийн мэдээ” БОХ4.1 маягт, “Цэвэр ус ашиглалтын 20...оны жилийн мэдээ” БОХ4.2 маягт, “Бохир ус цэвэрлэх байгууламжийн 20...оны жилийн мэдээ” БОХ 4.3 маягт, “Усны чанарын төлөв байдлын 20...оны жилийн мэдээ” БОХ 4.4 маягтаар гадаргын усны чанарын мэдээллийг жил бүрийн дүнгээр гаргаж сумын ЗДТГазар жил бүрийн 11-р сарын 25-ны дотор аймгийн БОАЖГазарт, Аймгийн БОАЖГазар 12-р сарын 1-ны дотор Усны газарт цахим хэлбэрээр ирүүлнэ гэж заасан байна. Маягтуудыг тооцоололоор нь задлавал:

- Нөхөн сэргээгдэх цэвэр усны нөөцийн талаарх мэдээллийг ихэвчлэн ус судлалын станцын удаан хугацааны хэмжилтийн түвшинд үндэслэн тооцооллыг хийнэ. Тооцооллыг хийхдээ урсацын коэффициент, гол болон нуурын дотогш/гадагш урсац, газрын доорх усны хаялбар, хур тунадасны хэмжээ зэргийг ашиглана. Энэ үзүүлэлт нь тухайн улсын усны балансыг тодорхойлоход хэрэглэдэг гол үзүүлэлт юм. Энэ нь “Цэвэр усны нөөц, хомсдлын 20...оны жилийн мэдээ” БОХ 4.1 маягтаар жилийн дүнгээр гаргана.
- Гадаргын цэвэр ус болон газрын доорх усны нөөцөөс тухайн жилд ашигласан нийт усны хэмжээ эдийн засгийн салбар тус бүрээр, түүнчлэн нөхөн сэргээгдэх цэвэр усны нөөцийн эзлэх хувиар тооцно. Цэвэр ус ашиглалтанд унд, ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглаж буй нийт цэвэр усыг хамруулан авч үзнэ. Зарим тохиолдолд унд, ахуйн, хөдөө аж ахуйн хэрэглээнд загвар, норм ашиглах шаардлагатай болдог. Ус ашиглалтын индекс нь жилийн дундаж цэвэр усны нөөцөд жилийн нийт ус ашиглалтын эзлэх харьцааг хувиар илэрхийлэн гаргасан үзүүлэлт юм. “Цэвэр ус ашиглалтын 20...оны жилийн мэдээ” БОХ 4.2 маягтаар жилийн дүнгээр гаргана.
- Бохир ус цэвэрлэх байгууламжийн ус ашиглалтын үзүүлэлт нь цэвэршүүлсэн, дахин ашигласан усны нийт хэмжээг цэвэршүүлсэн, дахин ашигласан ус болон бүтээгдэхүүн бий болгох хэрэглээнд зарцуулсан усны нийт дүнг харьцуулсан харьцаа юм. “Бохир ус цэвэрлэх байгууламжийн 20...оны жилийн мэдээ” БОХ 4.3 маягтаар гаргана.
- Усны чанарын төлөв байдлыг ундны усны эх үүсвэр (боловсруулсан ус, усан сан, булаг, худаг гэх мэт)-ээс авсан ундны усны сорьцын нийт тоонд ундны усны чанарын стандарт хангаагүй сорьцны эзлэх хувиар (шаардлага хангахгүй байгаа хувь) тодорхойлно. Усны чанарын төлөв байдлын 20...оны жилийн мэдээ” БОХ 4.4 маягтаар гадаргын усны чанарын мэдээллийг жил бүрийн дүнгээр гаргана.

Энэхүү маягтуудын дагуу гаргасан эсэхийг сумдын БОХУБ-аас тодруулан шалгахад нэг бүрчлэн нарийн гаргаж хийдэггүй, маягтын бөглөхөд мэдлэг чадвар дутмагаас хийж чаддаггүй, ус ашиглагч байдаггүйгээс хийдэггүй, сүүлийн 2-3 жил усны талаарх дээрх маягтуудыг хөтлөөгүйгээс мэдээгээ гаргаагүй, ус ашиглалтын талаарх мэдээг дутуу хагас гаргасан зэрэг нийтлэг зөрчлүүд байна.

Усны тухай хуулийн 18 дугаар зүйлийн аймаг нийслэлийн байгаль орчны албаны бүрэн эрхийн 18.1.2-д “аймаг, нийслэлийн усны мэдээллийн санг бүрдүүлж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, сав газрын захиргааг мэдээллээр хангах”, 18.1.3-д “усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, усан орчинг нөхөн сэргээх, ус хангамж, ариутгах татуургын болон хаягдал ус зайлуулах үйл ажиллагаанд хяналт тавих”, 18.1.4-д “ус ашиглагчид сав газрын захиргааны шийдвэр, энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулах, усны мэдээллийн санд бүртгэх” гэсэн заалтуудын хэрэгжилтэнд тавих хяналт хангалтгүй байна.

Усны тухай хуулиар 33.1.12-д ус ашиглалтын болон хаягдал усны бүртгэлийг хугацаанд нь явуулаагүй, тайлан, мэдээг үнэн зөв гаргаж өгөөгүй бол албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох заалттай бөгөөд энэ заалтаар арга хэмжээ тооцогдсон албан тушаалтан байхгүй байна.

3.3 Ус ашиглагч хэрэглэгчийн усны ногдуулалт, төлөлтөнд хяналт шалгалт хийгдсэн үү

Татварын хэлтэсээс усны төлбөрийн ногдуулалт, төлөлтөнд хяналт шалгалт хийгдэж 2.5 сая төгрөг нөхөн төлүүлсэн байна.

Усны тухай хуулийн 19.1.2-д ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг хууль тогтоомжийн дагуу ногдуулж, төлөлтөд хяналт тавих гэсэн заалтын дагуу байгаль хамгаалагч хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төв аймгийн Татварын хэлтэс 2016 онд татварын хяналт шалгалтаар усны төлбөрийн ногдуулалт, төлөлтөнд хийгдсэн хяналт шалгалтаар Сэргэлэн сумын Хустайн энгэр /цэвэр усны үйлдвэр/ 0.5 сая төгрөг, Батсүмбэр сумын Сансари ХХК 0.6 сая төгрөг, Омоо тэнгэр ХХК 0.1 сая төгрөг, Баянчандмань сумын Мон-Эгг ХХК 1.2 сая төгрөг, Борнуур сумын ХОМА ХХК 0.1 сая төгрөг нийт 2.5 сая төгрөгийн нөхөн төлбөрийг татварын улсын байцаагчийн актаар төлүүлж аймгийн төсвийн орлогод бүрэн төвлөрүүлсэн байна.

Усны төлбөрийн нөхөн төлбөрийг ногдуулалт хийснээр аймгийн Татварын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс мэдээлж байгаа нь өөрсдөө орлогоо бүрэн төлөвлөж чаддаггүй, ус ашиглагч, хэрэглэгчдийн нэгдсэн судалгаагүй байгаагийн тод жишээ юм.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Төв аймаг усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авч сууршлын бүс үүсгэхгүй байх бодлого баримтлан ажилласан байна.
2. Зарим сумд усны сан бүхий газарт энгийн хамгаалалтын бүс тогтоон улмаар ИТХ-ын шийдвэрээр орон нутгийн тусгай хамгаалалтад авчээ
3. Төв аймгийн нийт 915 усан сан бүхий газраас 11 сумын 420 буюу 45.9 хувьд нь энгийн хамгаалалтын бүс тогтоож, 16 сумын 262485.6 га талбай бүхий гол, мөрөн, нуур, цэнгэг усны орд газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, 151 булаг шанд, гол горхи, хөв цөөрөм, рашаан усны эхийг хамгаалсан байна.
4. Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д Усны тоо бүртгэлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга жил бүр зохион байгуулж, улсын усны мэдээллийн санд оруулна гэсэн заалт хэрэгжихгүй байна.
5. 513 худагийн мэдээллийг 2012-2017 онд мэдээллийн санд бүртгэсэн нь нийт худгийн 21.5 хувийг эзэлж байгаа нь усны тооллогыг жил бүр чанартай зохион байгуулдаггүйгээс мөн бодлогын хэлтсүүдийн ажлын уялдаагүйгээс мэдээлэл зөрүүтэй байна.
6. Ус ашиглуулах дүгнэлт гаргуулаагүй, ус ашиглах зөвшөөрөл аваагүй иргэн, аж ахуйн нэгж байгууллага 316 буюу 74.4 хувийг эзлэж байна.
7. Хүн амын ундны болон ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг бүрэн ногдуулж бодитой төлөвлөөгүй байна
8. 2016 онд аймгийн хэмжээний дүгнэлт гаргуулсан 30 аж ахуйн нэгжүүдээс 20 аж ахуйн нэгжид буюу 66.7%-д нь ус ашигласны төлбөр ногдуулаагүй байна.
9. Усны мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлж, мэдээлж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн Аймгийн Засаг дарга Ж.Батжаргал-д зөвлөх нь:

- Усны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, бодлогын хэлтсүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулахад анхаарч ажиллах

Сумдын Засаг дарга нарт зөвлөх нь:

- Эрх бүхий байгууллагын гаргасан дүгнэлт, зөвшөөрөлийг үндэслэн ус ашиглагч, хэрэглэгчтэй гэрээ байгуулан, хэрэгжилтэнд тавих хяналтыг сайжруулах

БОАЖГ-ын дарга Ж.Даш-яйчилд-д зөвлөх нь:

1. Аймгийн хэмжээний ус хэрэглэгч, ашиглагчдын судалгааг бүрэн гаргаж усны мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлж ажиллах
2. Усны тооллогыг жил бүр үнэн зөв бодитой явуулж, худгийг ашиглалтын байдлаар, эзэмшигчээр, төрлөөр, зориулалтаар, ашиглаж эхэлсэн огноогоор, шинжилгээг хийлгэсэн талаар, худгийн барилга байгууламжийн паспортын талаарх дэлгэрэнгүйгээр статистик судалгаагаар тооллогыг чанартай хийх талаар арга хэмжээ авч зохион байгуулж ажиллах
3. Цэвэр усны нөөц, хомсдол, цэвэр ус ашиглалт, бохир ус цэвэрлэх байгууламж, усны чанарын төлөв байдлын мэдээг батлагдсан маягтаар гадаргын усны чанарын мэдээллийг жил бүрийн дүнгээр гаргуулж нэгтгэж хэвшүүлэх

Татварын хэлтсийн дарга Д.Батсайхан-д зөвлөх нь:

- Ус ашиглагч, хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тус бүртэй усны төлбөрийн ногдуулалтыг хийж хөнгөлөлт, чөлөөлөлтийг бүрэн хийж, ногдуулалтыг бодитой тооцож байх.
- Урьд оны татварын дутуу төлөлтийн мэдээг тайланд тусгаж, гүйцэтгэлийг үнэн зөв тооцож байх.

ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:
АУДИТОР

Ц.БАЗАРСАД
Ц.САРАНЧИМЭГ

